Аудитыг "Грант Торнтон аудит" ХХК-ийн ахлах аудитор Г.Батхишиг, туслах аудитор Б.Эрдэнэболд, Д.Буянтогтох, Н.Даваажаргал нар гүйцэтгэж, хяналтыг "Грант Торнтон аудит" ХХК-ийн аудитын менежер Л.Болорцэцэг, НТАГ-ын аудитын менежер А.Цогбаяр, хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг "Грант Торнтон аудит" ХХК-д 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 42 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв нь салбарын бодлого, төлөвлөлтийг нотолгоонд тулгуурлан хэрэгжүүлэх, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, эрт илрүүлэлт, үзлэгийг олон улсын жишигт хүргэх, статистик ач холбогдлыг дээшлүүлэхэд анхаарч ажиллах зорилго тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14<sup>1</sup> дүгээр зүйл 14<sup>1</sup>.3-д "Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүнийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж таван жилийн хугацаагаар томилж, чөлөөлөх бөгөөд нэг удаа улируулан томилж болно." 23 дугаар зүйл 23.2.1-д "эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах төлөвлөгөө, зөвлөмж боловсруулж хэрэгжүүлэх"
- Эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйл 7.1.3-д "эрүүл мэндийн талаар батлагдсан бодлого, хөтөлбөрийг санхүүжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих"

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.



Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, түүний дотор дотоод аудиторын тайлант оны ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар Эрүүл мэндийн яам, Нийслэлийн эрүүл мэндийн газраас дотоод хяналт шалгалт ороогүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 9,857.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 98.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 73.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Учир нь гүйцэтгэлийн материаллаг байдлын зөрүү дүн нь 297.3 сая төгрөг байна. Материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нийт зардал нь өмнөх оныхоос 3 дахин нэмэгдсэн байна. Тухайлбал: Норматив зардал 24,998.4 сая төгрөгөөр, Бараа үйлчилгээний бусад зардал 3,351.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь Ковид-19 цар тахалтай холбоотой вакцины зардал, ЭМА-уудын нэг удаагийн мөнгөн тэтгэмж, дархлаажуулалтын зардал, тусгаарлах байрны төлбөр гэх мэт зардлууд материаллаг дүнгээр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Иймд гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 39,593.5 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 395.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 296.9 сая төгрөгөөр тогтоосон.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,982.5 сая төгрөгөөр буюу 50.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, засгийн газрын хувь оролцоо данс байна.



Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	32.3	32.3
Авлага	-	3,064.9	3,064.9
Урьдчилж гарсан зардал	3.8	4.8	1.0
Бараа материал	702.7	1,509.8	807.1
Үндсэн хөрөнгө	7,185.3	7,262.5	77.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>7,891.8</b>	<b>11,874.3</b>	<b>3,982.5</b>
Өр төлбөр	2.5	629.2	626.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,889.3	11,245.1	3,355.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>7,891.8</b>	<b>11,874.3</b>	<b>3,982.5</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 32.3 сая төгрөгөөр өссөн нь төрийн сангийн харилцах 2.2 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн харилцах 30.1 сая төгрөгийн харилцахын үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ. Тайлант хугацаанд харилцахын үлдэгдлийг төвлөрүүлээгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 3,064.9 сая төгрөг болж 3,064.9 сая төгрөгөөр өссөн нь ЭМДЕГ-аас авах авлага 3,064.5 сая төгрөг, хувь хүнээс авах авлага 0.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд он удаан жил болсон авлагын үлдэгдэл байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,509.8 сая төгрөг болж 807.1 сая төгрөгөөр өссөн нь эм боох материалын үлдэгдэл өссөнөөс шалтгаалжээ. Эм боох материал нь төсвийн хөрөнгөөр 1,966.1 сая төгрөг, хандиваар 27,201.5 сая төгрөг, шилжүүлэн авсан 1.4 сая төгрөг нийт 29,169.0 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд 27,219.6 сая төгрөгийн материал зарцуулж, 1,072.1 сая төгрөгийн материал шилжүүлсэн байна. Эм боох материалын данснаас хугацаа дууссан, цаашид ашиглах боломжгүй устгалд оруулах 181.3 сая төгрөгийн вакциныг холбогдох журмын дагуу акталж, устгаж хасалт хийсэн байна. Жилийн эцсийн бараа материалын үлдэгдэл өмнөх үеийнхээс харьцангуй их байгаа нь Ковид-19 цар тахалтай холбоотой 2 сарын нөөц үүсгэж, худалдан авалт хийсэн байна

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,262.5 сая төгрөг болж 77.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдэл, балансаас балансад шилжүүлсэн хөрөнгө болон акталснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь худалдан авсан 75.0 сая төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 889.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд 871.5 сая төгрөгийн элэгдлийн зардал гарсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 629.2 сая төгрөг болж 626.7 сая төгрөгөөр өссөн нь гэрэл цахилгааны өглөг 12.0 сая төгрөг, эмийн өглөг 236.4 сая төгрөг, урсгал засварын өглөг 2.3 сая төгрөг, бараа үйлчилгээний зардлын өглөг 378.5 сая төгрөг нэмэгдсэнээс шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 31,387.0 сая төгрөгөөр буюу 3.6 дахин өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг дүнгээр нэмэгдсэн нь эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, нэмэлт санхүүжилтийн орлогоос шалтгаалсан байна. Тухайлбал: Ковид 19 цар тахалтай холбоотой Эрүүл мэндийн яам,



Нийслэлийн эрүүл мэндийн газар, НЗДТГ, Нийслэлийн онцгой комисс, хувийн компаниуд эм, эмнэлгийн багаж тоног төхөөрөмжүүдийг үнэ төлбөргүй хүлээн авсан.

Нийт зардал өмнөх оноос 29,736.2 сая төгрөгөөр буюу 4 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг дүнгээр нэмэгдсэн нь цалингийн зардал, норматив зардал буюу эм боох материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд өссөнтэй холбоотой байна. Тухайлбал: эм боох материалын зардал дансанд Ковид 19 цар тахалтай холбоотой вакцин, нэг удаагийн маск, бээлий, комбинезон №1, ариутгалын бодис гэх мэт зардлууд гарсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 8.3 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга бүртгэсэнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 7,755.7 сая төгрөгөөр, нийт зарлагыг 7,755.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс санхүүжилтийн орлогыг 1,194.7 сая төгрөгөөр бууруулж 6,561.0 сая төгрөгөөр баталсан байна. Төсвийн төслийн материаллаг өөрчлөлттэй нь улсын төсвөөс 1,486.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, эрүүл мэндийн даатгалын сангаас 211.6 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 80.1 сая төгрөгөөр бууруулж баталсантай холбоотой байна.

Төсвийн тодотголыг 2021 оны 12 дугаар сарын 06-нд хийсэн бөгөөд санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,594.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 9,155.4 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2,594.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 9,155.4 сая төгрөгөөр өөрчлөн баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 9,155.4 сая төгрөгийн төсөв баталснаас 8,944.4 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас 211.0 төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 8,412.8 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 213.5 сая төгрөг, нэмэлт санхүүжилтээр 210.0 сая төгрөг, төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилтээр 100.0 сая төгрөг нийт 8,936.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагаанд 8,934.2 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2.1 сая төгрөгийн харилцахын үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 8,934.2 сая төгрөг буюу 97.6 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 89.5 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, норматив зардал, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 131.7 сая төгрөгөөр тус тус төсвийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.



### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ДЭМБ, НҮБ-ын хүн амын сан 194.9 сая төгрөг, Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газар 87.9 сая төгрөг, Эрүүл мэндийн яам, Нийслэлийн эрүүл мэндийн газар 2,306.4 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого болох ПГУ шинжилгээний орлого 199.0 сая төгрөг нийт 2,788.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа ажил үйлчилгээний бусад зардалд 2,366.6 сая төгрөг, цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 389.9 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 1.6 сая төгрөг нийт 298,887.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 30.1 сая төгрөгийн харилцахын үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

#### Асуудлыг онцолсон хэсэг:

Санхүүгийн тайлангийн болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь Эрүүл мэндийн даатгалын сангаас 11,787.3 сая төгрөгийн санхүүжилтийн орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 27,485.6 сая төгрөгийн орлого хүлээн авсан бөгөөд үүнээс ХӨСҮТ-өөс 21,572.9 сая төгрөгийн бараа материал шилжүүлэн авсан ба уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

#### Бусад асуудлын хэсэг:

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 27 зорилтын хүрээнд 72 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 85.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.8. Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 03 дугаар тогтоол хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжилт авч, тайлан хугацаанд ЭМДЕГ-аас 3,064.5 сая төгрөгийг авлагыг тайлагнасан бөгөөд тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.



### 3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 11 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 15,904.7 сая төгрөгийн 310 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2,124.3 сая төгрөгийн 25 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна. Үүнд:

- Шилэн дансны цахим хуудсанд орлого, худалдан авалтын 1,876.6 сая төгрөгийн 14 мэдээллийг, зарлагын 247.7 сая төгрөгийн 11 мэдээллийг тус тус хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3. "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйл 6.1. "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу 6 удаагийн 211.9 сая төгрөгийн худалдан авалт хийж, зохион байгуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10. Завсрын аудитын үр дүн, Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 3.10.1. Завсрын аудитын үр дүн:

2021 оны III улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар нийт 971.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 915.6 сая төгрөгийн алдааг залруулга хийлгэж, 55.9 сая төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 915.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, 55.9 сая төгрөгийн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

#### 3.10.2. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 12.7 сая төгрөгийн зөрчлийн төлбөрийг барагдуулж 2 актыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 5.5 сая төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.



Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

*/сая төгрөг/*

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	12.7	2	12.7	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	1	5.5	1	5.5	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>18.2</b>	<b>3</b>	<b>18.2</b>	-	-	-

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу байгаа эсэх мөн ЭМДЕГ-ын цахим систем (<https://health.gov.mn>)-д гүйцэтгэлээр үндсэн санхүүжилтэд дотоод хяналтын систем байгаа эсэх нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 925.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 338.6 сая төгрөгийн алдааг залруулга хийлгэж, 587.1 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдаа санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- ЭМДЕГ-ын 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 08/1747 албан тоотын дагуу 12 дугаар сард үзүүлсэн тусламж үйлчилгээний гүйцэтгэлээ 12 дугаар сарын 10-ний өдрөөр тасалбар болгон тооцоо нийлсэн бөгөөд 12 сарын 13-31-ний өдрүүдэд хамаарах үйлчилгээний орлогыг 338.6 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.

### 4.2 Албан шаардлага

1. 2021 оны 4 дүгээр улирлын байдлаар 324 хүний орон тоо буюу 49 орон тооны илүүдэлтэй ажиллаж, эдгээр илүүдэл орон тоонд 581.2 сая төгрөгийн цалингийн зардал гаргасан байна. *(нэгдсэн эмнэлгийн дарга, эмч, сувилагч, ариутгагч, тогооч, үйлчлэгч, цахилгааны инженер, жолооч)* Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.3. "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.

2. НӨАУГ-ын зөвшөөрөлгүйгээр төсөв төлөвлөгөөнд батлагдаагүй нийт 5.9 сая төгрөгийн *(компьютер тоног төхөөрөмж, тавилга эд хогшил)* хөрөнгө худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн



33.2.1-т "үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүрд мэдээлэх" заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.

#### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа НБББББ-ийг 2011 онд боловсруулж, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа боловч холбогдох хууль, дүрэм журмын шинэчлэл хийгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.2-д "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" заалтад нийцэхгүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, УСНББОУС, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг сайжруулан боловсруулж, мөрдөж ажиллах.

#### 2. Дотоод хяналтын үйл ажиллагаатай холбоотой асуудал

##### 2.1. Илрүүлэлт:

Дотоод хяналтын үйл ажиллагааг байгууллагын онцлогт тохируулан хууль, журамд нийцүүлэн боловсруулсан бодлого журамгүйгээс дараах зөрчил байна. Тухайлбал:

- Дарга нь 2018 оноос одоог хүртэл байгууллагын бүтэц орон тоог шинэчлэн батлуулаагүй байна. Тайлант хугацаанд 49 ажилтны орон тоо нэмэгдүүлэн үйл ажиллагааг явуулж байна.
- Ахлах нягтлан бодогчийг Төсвийн тухай хууль, төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, тэдгээрийн эрх, үүрэг, ажилд томилох, чөлөөлөх журмын шалгуураар томилоогүй.
- Үндсэн хөрөнгийн эзэмшигчийн карт болон кодчилол байхгүй, ижил төрлийн хөрөнгүүд бүгд нэг кодтой, санхүүгийн программ дахь кодоор кодлогдоогүй, нэршил тодорхой бус байгаа нь санхүүгийн үйл ажиллагааны хяналт хийгддэггүй байна.
- ЭМТ-өөр үйлчлүүлсэн иргэн тус бүрийн мэдээллийг ЭМДЕГ-ын цахим систем (<https://health.gov.mn>)-д шивж оруулан, сар бүрийн гүйцэтгэлийн дүнг нэгтгэн нийт 10,817.0 сая төгрөгийн санхүүжилтийг нэхэмжилсэн боловч ЭМДЕГ 3,710.4 сая төгрөгийн (иргэдийн регистр, даатгал хэтрэлттэй, онош зөрүүтэй, зэрэг шалтгаан) гүйцэтгэлийн санхүүжилтийг баталгаажуулаагүй байна.

Аливаа зальт үйл ажиллагаа бий болж, төсвийн хөрөнгийг зүй бусаар зарцуулах, санаатай болон санамсаргүй байдлаар алдаа, зөрчил үүсэх, хөрөнгө шамшигдах өндөр эрсдэлтэй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6. "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого

хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заасантай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаануудаа чухал, эрсдэлтэй, хэвийн гэж ангилж, тэдгээрт тохирсон зохистой хяналтын үйл ажиллагаануудыг тодорхойлж, өдөр тутмын хяналтын үйл ажиллагааны процессын зураглалыг боловсруулж, зохих албан тушаалтнуудын ажил үүргийн хуваарьт тусгаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллага болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	/сая төгрөгөөр/										
		Нийт алдаа, зөрчлийн		Запруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар</b>												
1	Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа НБББББ-ийг 2011 онд боловсруулж, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа боловч холбогдох хууль, журмын шинэчлэл хийгээгүй байна.	1	-	-	-	-	-	-	-	-	1	-
2	<p>Дотоод хяналтын үйл ажиллагааг байгууллагын онцлогт тохируулан хууль, журамд нийцүүлэн боловсруулсан бодлого журамгүйгээс дараах зөрчил байна. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Дарга нь 2018 оноос одоог хүртэл байгууллагын бүтэц орон тосг шинэчлэн батлуулаагүй байна. Тайлант хугацаанд 49 ажилтны орон тоо нэмэгдүүлэн үйл ажиллагааг явуулж байна,</li> <li>• Ахлах нягтлан бодогчийг төсвийн тухай хууль, төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, тэдгээрийн эрх, үүрэг, ажилд томилох, чөлөөлөх журмын шалгуураар томилоогүй,</li> <li>• Үндсэн хөрөнгийн эзэмшигчийн карт болон кодчилол байхгүй, ижил төрлийн хөрөнгүүд бүгд нэг кодтой, санхүүгийн программ дахь кодоор кодлогдоогүй, нэршил тодорхой бус байгаа нь санхүүгийн үйл ажиллагааны хяналт хийгддэггүй байна</li> <li>• ЭМТ-өөр үйлчлүүлсэн иргэн тус бүрийн мэдээллийг ЭМДЕГ-ын цахим систем (<a href="https://health.gov.mn">https://health.gov.mn</a>)-д шивж сруулан, сар бүрийн гүйцэтгэлийн дүнг нэгтгэн нийт 10,817.0 сая төгрөгийн санхүүжилтийг нэхэмжилсэн боловч ЭМДЕГ 3,710.4 сая төгрөгийн (иргэдийн регистр, даатгал хэтрэлтэй, онош зөрүүтэй, зэрэг шалтгаан) гүйцэтгэлийн санхүүжилтийг баталгаажуулаагүй байна. ЭМДЕГ-ын цахим систем (<a href="https://health.gov.mn">https://health.gov.mn</a>-д гүйцэтгэл санхүүгийн үндсэн санхүүжилтийг баталгаажуулж чадаагүй программыг сайжруулах.</li> </ul>	1	-	-	-	-	-	-	-	-	1	-

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Д/Д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
3	Эрх бүхий дээд байгууллага (НӨАУГ)-ын зөвшөөрөлгүйгээр дур мэдэн, төсөв төлөвлөгөөнд батлагдаагүй нийт 5.8 сая төгрөгийн (компьютер тоног төхөөрөмж, тавилга эд хогшил) хөрөнгө худалдан авсан байна.	1	5.9	-	-	-	-	1	5.9	-	-
4	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 31-ний А/4 дүгээр тушаалаар БЗД-ийн Эрүүл мэндийн төвийн орон тоо, бүтцийг нийт 275 хүнээр баталсан байна. Гэвч байгууллага 2021 оны 4 дүгээр улирлын байдлаар 324 хүний орон тоо буюу 49 орон тооны илүүдэлтэй ажиллаж, эдгээр илүүдэл орон тоонд 581.2 сая төгрөгийн цалингийн зардал гаргасан байна.	1	581.2	-	-	-	-	1	581.2	-	-
5	Тухайн байгууллага нь ЭМДЕГ-ын 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 08/1747 тоо албан тоотын дагуу 12 дугаар сард үзүүлсэн тусламж үйлчилгээний гүйцэтгэлээ 12 дугаар сарын 10-ний өдрөөр тасалбар болгон тооцоо нийлсэн бөгөөд 13-31-ний өдрүүдэд хамаарах үйлчилгээний орлогыг акрүэль суурийн дагуу хүлээн зөвшөөрч бүртгэдэггүйгээс орлого буруу тайлант үедээ хүлээн зөвшөөрсөн байна.	1	338.6	1	338.6	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>		<b>5</b>	<b>925.7</b>	<b>1</b>	<b>338.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>587.1</b>	<b>2</b>	<b>-</b>
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>											
1	Шилэн дансны цахим хуудсанд орлого, худалдан авалтын 1,876.6 сая төгрөгийн 14 мэдээллийг, зарлагын 247.6 сая төгрөгийн 11 мэдээллийг тус тус хугацаа хоцроож байршуулсан	1	2,124.3	-	-	-	-	1	2,124.3	-	-
<b>Дүн</b>		<b>1</b>	<b>2,124.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>2,124.3</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>		<b>6</b>	<b>3,050.0</b>	<b>1</b>	<b>338.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>2,711.4</b>	<b>2</b>	<b>-</b>



## АУДИТЫН ТАЙЛАНГ

### БЭЛТГЭСЭН:

“ГРАНТ ТОРНТОН АУДИТ” ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР



Г.БАТХИШИГ

### ХЯНАСАН:

“ГРАНТ ТОРНТОН АУДИТ” ХХК-ИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Б.ОСОРГАРАВ